UBS STAR HD MNC MNB

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Монгол улс дахь ОХУ-ын ЭСЯ

РЦНК TUMED GROUP

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ОХУ-ын ЭСЯ, БСШУСЯ-ны дэмжлэгтэйгээр Оросын шинжлэх ухаан соёлын төв (РЦНК)



РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА

ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2019

03.14-16

4 ДАХЬ УДААГИЙН

ОРОСЫН БОЛОВСРОЛ - ДЭЛХИЙН БОЛОВСРОЛ

ОХУ-Д СУРАЛЦАХ ДАВУУ ТАЛУУД:

- Монголд хамгийн их тэтгэлэгт хөтөлбөртэй
- Монголд ойрхон
- Амьдралын өртөг хямд
- ОХУ бол дэлхийн соёл, шинжлэх ухааны төв

ЭРХЭМ ХҮНДЭТ МОНГОЛ АНД НӨХӨД ӨӨ!

Та бүгдийн гар дээр байгаа энэхүү лавлах нь Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төв болоод монголын охид хөвгүүдэд оросын залуустай хамт суралцах боломжийг олгож байгаа оросын тэргүүлэх сургуулиудтай танилцах боломжийг олгож байгаа юм.

Чанартай боловсрол бол Орос Улсын хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлийн нэг мөн. Оросын их дээд сургуулиуд оюутнуудыг дэлхийн түвшинд сургаж, өндөр мэргэжлийн эрэлт хэрэгцээтэй мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргадаг билээ.

Оросын боловсрол нь хүнийг хувь хүн талаас нь боловсруулж хөгжүүлэхээс гадна мэргэжлээрээ ахих ирээдүйн боломжийг олгодог юм. Түүнчлэн сонгосон мэргэжлийн хувьд гүн гүнзгий мэдлэг олгохоос гадна тэргүүлэгч эрдэмтэдийн удирдлага дор эрдэм шинжилгээний ажил хийх, эрдэм шинжилгээ-судалгааны төслүүдэд оролцуулж тэдгээрийг амьдралд бодитой хэрэгжүүлэх боломжийг нээж өгдөг. Орос Улсад суралцах явдал нь орос үндэсний ёс уламжлал, оросын ба дэлхийн соёлтой танилцах, орос хүмүүсийг Монгол Улсын үндэстэн ястнуудын ёс уламжлал, соёлтой танилцуулах хосгүй боломжийг нээж байгаа юм. Их дээд сургуулиудын төгсөгчдийн хувьд цаашид эрдэм шинжилгээний ажил хийх, сурган хүмүүжүүлэх үйлсэд амьдралаа зориулах, олж авсан мэргэжилдээ улам мэргэших, цаашлаад аспирантур болон төрөл бүрийн дадлагажих сургалтанд хамрагдах өргөн боломж нээлттэй байна.

Та бүхэн яг одоо цаашдын амьдралыг тань тодорхойлох чухал сонголтын өмнө зогсож байгаа. Та бүгдийн өмнө олон зам харгуй нээлттэй байгаа бөгөөд тэрхүү замаа зөв сонгож авахыг бид чин сэтгэлээсээ хүсч байна!

Та бүхнийг оросын их дээд сургуулийн оюутнуудын дунд орж суралцахад бид ямагт баяртай байх болно.

Манай улсын их дээд сургуулиуд таны сонирхолыг татаж, сэтгэлд тань тааламжтай байхын төлөө бид чадах бүхнээ хийх болно.

Орос Улсад тавтай морилно уу!

Т.Ч. Будаева

Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга, Россотрудничество агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүний үүрэг гүйцэтгэгч

ОРОСЫН УЛС ТҮМНИЙ НАЙРАМДЛЫН ИХ СУРГУУЛЬ

5100 RUSSIAN ACADEMIC EXCELLENCE PROJECT

Улс түмний найрамдлын их сургууль (РУДН)нь 1960 онд ЗСБНХУ-ын Засгийн газрын тусгай тогтоолоор «Патрис Лумумбын нэрэмжит Улс түмний найрамдлын их сургууль» хэмээн байгуулагдаж, өнөөг хүртэл гадаадын оюутнуудыг олон талын өргөн мэргэжлээр бэлтгэх талаар оросын тэргүүлэх их сургууль болсон юм. Тус сургуулийг төгсөгч 100000 гадаад төгсөгчид дэлхийн бараг бүх оронд ажиллаж байна.

Тэдний дунд олон ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд нар, нэртэй улс төрчид, бизнесменүүд, эрдэмтэд, нийгэм, соёлын зүтгэлтнүүд байна.

Тус их сургуулд 6 факультет, 10 институт, 1 академи, 156 шинжлэх ухаан-боловсролын лаборатори, нийтээр ашиглах 4 төв тус тус ажилладаг. Сургууль нь дараахь факультет/институтээр мэргэжилтэн бэлтгэн гаргаж байна:

- Газар тариалан-технологийн институт;
- Хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны Факультет;
- Инженерийн академи;
- Анагаан ухааны институт;
- Хэл шинжлэлийн факультет;
- Физик-математик, байгалийн ухааны Факультет;
- Экологийн факультет;
- Зочид буудлын бизнес, аялал жуулчлалын Институт;
- Орос хэл, ерөнхий боловсролын хичээлийн Факультет;
- Гадаад хэлний Институт;
- Дэлхийн эдийн засаг, бизнесийн Институт;
- Биохимийн технолог, нанотехнологийн Институт;
- Гравитаци, космологийн сургалт-шинжлэх ухааны институт;
- Харьцуулсан боловсролын бодлогын сургалт-шинжлэх ухааны институт;
- Эдийн засгийн факультет;
- Хуулийн институт

Нийт оюутны тоо 31766, үүнээс 8295 нь дэлхийн 157 орноос ирсэн гадаад оюутнууд.

РУДН-ийн оюутны хотхон Москва хотын Засгийн газраас Москва хотын их дээд сургуулиудын дунд шилдгээр шалгарч, бүх оросын «Шилдэг оюутны дотуур байрны төлөө» уралдаанд түрүүлсэн юм.

Бид өөрийн кампусаараа бахархдаг — Энэ бол 8000 оршин суугчтай жинхэнэ хотхон. Оюутны 14 дотуур байр нь хичээлийн үндсэн корпустайгаа маш ойрхон байдаг. Ойн паркын бүсний ойролцоо 50 га талбайд спортын цогцолбор, хэд хэдэн стадион, концертын зал, клиник, номын сан, үндэсний хоолны 30 гаруй кафе, дэлгүүр, дэлгүүр, ахуй үйлчилгээний газрууд, унадаг дугуйны зогсоолуудтай.Харин кампусын гол зүрх нь оюутнуудын амрах дутай газар болох усан оргилуурууд юм.

РУДН-ийн нутаг дэвсгэр дээр хотын поликлиник, мэргэжлийн анагаах ухааны зөвөлгөө, тусламж үзүүлдэг эмчилгээ-урьдчилан сэргийлэх газар тус тус байдаг.

24 цагийн ажиглалт хийдэг 2000 видеокамертай. Хичээлийн бүх байр, оюутны бүх дотуур байрууд орох гарахыг хянадаг хяналтын цахим системтэй. Гал түймрийн автомат дохиололттой. РУДН-ийн нутаг дэвсгэр дээр өөрийн цагдаагийн хэсэг ажилладаг.

Сургуулийн нутаг дэвсгэр дээр интернационал төв (Интерклуб) ажилладаг бөгөөд түүний 30 ансамбль, дугуйлангийн аль дуртайд нь оюутнууд чөлөөт цагаараа хичээллэж болно. 150 оюутны нэгдлүүд дотор монгол оюутнуудын нугийн зөвлөл ажилладаг.

ХОЛБОО БАРИХ:
ХАЯГ: 117198, МОСКВА, УЛ. МИКЛУХО-МАКЛАЯ, Д. 6 УТАС.: +7 (495) 787-38-03, ДОБ. 17-84
E-MAIL: DIS@RUDN.UNIVERSITY HTTP://WWW.RUDN.RU

УРАЛЫН УЛСЫН ХУУЛИЙН ИХ СУРГУУЛЬ

Уралын улсын хуулийн их сургууль нь 1918 онд байгуулагдсан бөгөөд Оросын хамгийн их нэр хүндтэй боловролын байгууллагуудын нэг юм. Тус сургуулийн сургалт нь олон улсын түвшинд чиглэгдсэн бөгөөд мэдээллийн технологи, оросын улсын болон олон улсын боловсролын стандартад суурилсан байдаг. Манай сургууль хуулийн мэргэжилтэн бэлтгэх талаар гадаадын олон их сургуулиудтай үр бүтээлтэй хамтран ажилладаг.

Манай сургууль нь өндөр чадварлаг хуульчдыг бэлтгэхдээ дээд сургуулийн шилдэг уламжлал, эрх зүйн үнэт зүйлсийг баримтладаг эрдэмтэд, багш ажилтны хамт олон юм.

Манай сургууль нь төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, улсын

корпорацууд, шүүх, хууль, прокурор, аюулгүй байдал, мөрдөн, гааль, татварын алба, санхүү, банк, хөрөнгө оруулалт, даатгалын байгууллагуудаас гадна үйлдвэрлэл, гадаад эдийн засаг, консалтинг(аудит, маркетинг), үл хөдлөх хөрөнгийн эргэлт, олон улсын болон дипломат, консулын газар, гадаадын хөрөнгө оруулалт бүхий компани, гадаадын байгууллагуудад ажиллах өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргадаг.

Бид бүхэн өвөрмөцөөр сэтгэдэг, харилцаа сайтай, амбицтай, амжилтанд хүрэх чаадвартай хүмүүсээс гадна бие даасан сонголтыг хийж чаддаг, их ажиллахад бэлэн, хариуцлагыг өөртөө авч чаддаг хүмүүсийг сонирхдог.

Өнөөдөр Уралын улсын хуулийн их сургууль нь эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, өндөр мэргэжлийн хуулийн боловсон хүчнийг бэлтгэх талаар Орос Улсад хамгийн том их сургуулийн нэг юм.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг манай сургуулийн дорх сайтуудаас орос хэл дээр олж авна уу:: ***http://www.usla.ru/***

ХОЛБОО БАРИХ:
СУРГУУЛИЙН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛСТИЙН ХАРИЛЦАХ МЭДЭЭЛЭЛ: +7 (343) 374-40-12, ЭЛ. ПОЧТА:UMS@USLA.RU

ВЛАДИВОСТОКИЙН ЭДИЙН ЗАСАГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Владивостокийн эдийн засаг, сервисийн улсын их сургууль нь ОХУ-ын Холбооны Алс Дорнодын тойргийн нийслэлВладивосток хотод байдаг бөгөөд улс орны эдийн засгийн хүчирхэг дээд сургуулийн нэг юм. Тус их сургуулийн жилээс жилд олдог ололт амжилтыг нь бүс нутаг, холбооны түвшин, олон улсын хэмжээний түвшинд олж авсангрант, шагналууд тодорхойлон баталж байна.

Тус их сургуулийн кампус нь дэлхийн шилдэг загвараас баригдсан хичээлийн болон орон сууцны корпус, спорт, эрүүлжүүлэх, чөлөөт цагийг өнгөрүүлэх цогцолборууд, кафе, дэлгүүр сервис үйлчилгээний албууд нь нэгэн дээвэр дор видео камертай байдаг ба хотын иргэдэд нээлттэй байдаг. Оюутнуудын суралцах, жижиг үйлдвэрлэл эрхлэх, уран бүтээлийн хувьд өсөх болон эрүүл аж төрөх бүх нөхцөл бүрдсэн байдаг.

ВЭЗСУИС нь орчин үеийн чанартай дээд боловсрол төдийгүй сургалтын дээд зэргийн баталгаа юм. Тус их сургуулийг төгсөгчдийн 70 % сургууль төгссөнийхөө дараа шууд ажилд ордог бөгөөд тус их сургуульд хэрэгжүүлж байгаа боловсролын бүх хөтөлбөр нь бүх оросын болон дэлхийн хөдөлмөрийн зах зээл дээр хэрэгцээ шаардлагатайбайдаг.Оюутнууд 4-р курстээ сургуулийнхаа стратегийн түншүүд болох үйдвэрийн газрууд дээр 7 сарын дадлага хийдэг ба энэ нь тэдэнд мэргэжлээрээ ажлын шаардлагатай туршлагыг олж авах бодит боломжийг олгож байна.

ВЭЗСУИС-д гадаадын 600 гаруй оюутнууд төлбөртэй суралцдаг ба мөн ОХУ, Узбекистан, Армени, Украин, Гүрж, Киргиз, Азербайджан, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Лаос, Нигер, Конго, Афганистан, АНУ болон бусад орны засгийн газрын тэтгэлээр олон оюутнууд суралцдаг. Гадаадын оюутнууд ВЭЗСУИС-ийн дээд боловсролын хөтөлбөр, хоёр дипломын хөтөлбөрөөр суралцаж улсын диплом гардаг авдаг. Мөн тус сургуульд оюутан солилцох хөтөлбөрөөр гадаадын түнш их сургуулиудын оюутнууд ирж суралдаг юм.

Гадаадын оюутнуудын эзэмших дуртай мэргэжил ньХэл шинжлэл, эдийн засаг, менежмент, дизайны мэргэжлүүд юм.

ВЭЗСУИС нь гадаадын түнш байгууллагуудтайгаа түншийхээ харилцааг бэхжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна: хоёр талын хамтын ажиллагааны 65 хэлэлцээр, гадаадын 15 түнш байгууллага, солилцооны 25 хамтарсан хөтөлбөр, "давхар дипломын"5 хөтөлбөрийг хэрэгжүүлэж байна.

ВЭЗСУИС-ийн оюутан бүр олон улсын боловсрол, туршлага олж авах боломж байдаг ба сургууль БНХАУ, Япон, Өмнөд Солонгос, АНУ-ын 13 их сургуультай солилцооны

хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Оюутнууд солилцооны хөтөлбөрийн хүрээнд гадаадын түнш их сургууль дээр 1-2 семестрийн туршид үнэгүй суралцаж, гадаад хэлнийхээ мэдлэгийг дээшлүүлэн, өөрийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд хичээллэж, тухайн орны соёлтой танилцдаг.

Владивостокийн эдийн засаг, сервисийн улсын их сургуульд тавтай морилно уу!

ХОЛБООБАРИХ:
УТАС: 8 (423)240-41-38
И-МЭЙЛ: INTERNATIONAL@VVSU.RU
ХАЯГ: РОССИЯ, Г. ВЛАДИВОСТОК, УЛ. ГОГОЛЯ 41

4 ДАЛЬ УДААГИЙН

ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2019

РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА

ITMO UNIVERSITY

САНКТ-ПЕТЕРБУРГИЙН ҮНДЭСНИЙ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЕХАНИК, ОПТИКИЙН ИХ СУРГУУЛЬ

ИТМО(сургуулийн орос товчлол) их сургууль нь Оросын соёл, шинжлэх ухаан-боловсрол, инновацийн хосгүй төв болох Сант-Петербург хотод оршдог. Тус сургууль 1900 оны 3 сарын 26-нд байгуулагдсан бөгөөд мэдээлэл, фотонны технологийн салбарт Оросын тэргүүлэх их сургууль юм.

Тус их сургууль дэлхийн шилдэг 100 IT их сургуулийн тоонд орж, Computer Science салбар дахь THE рейтингэд 71-р байр, инженер, физикийн ухаанаар ТОП -400 их сургуулийн нэг болж, цахилгаан, элэктрон инжинирингээр ТОП-250 их сургуулийн тоонд тус тус ордог.

ИТМО их сургууль нь олон улсын оюутны багийн програмчлалын тэмцээнд ганцаараа 7 удаа түрүүлсэн. Сургуулийн төгсөгчид ANDROID-д зориулсан ажлуудын албан ёсны хэл болох KOTLIN хөтөлбөрийг зохиосон.

ИТМО их сургууль нь инновацийн хосгүй бүтэцтэй сонгодог бус их сургууль: 2 бизнес-инкубатор, Технопарк, Үлл бодол, арга зүй, практикийн нээлттэй лаборатори, ФабЛаб дархны газар-лаборатортой.

Бидний зорилго бол өрсөлдөх чадвартай бие хүнийг өв тэгш хөгжүүлэх боломжийг нээж, глобал зорилтуудыг шийдвэрлэхэд зоригжуулах явдал юм. Сургууль нь боловсролын процесст инновацийн аргаар ханддаг. Бүх хөтөлбөрүүд тодорхой чиглэлүүдэд ангилагдсан. 5 мега чиглэл- 5 шинжлэх ухааны трендтэй.

Мэдээлэл технологийн дамжуулах Мегафакультет (хиймэл оюун ухаан, өндөр бүтээмжит тооцооллын технологи). **Компьютерийн технологи,** удирдлагын Мегафакультет (киберфизикийн систем, робототехника, мэдээллийн болон кибераюулгүй байдал). **Фотоникийн Мегафакультет** (оптик технологи ба лазерын систем, квантынхарилцаа ба шинэ функциональ материал). **Биотехнологи болон нам температурын системийн Мегафакультет** (биотехнологи, хөргөх технологи, хүнсний инноваци бүтээгдэхүүн, хүрээлэн байгаа орчныг хамгаалах). **Технологийн менежмент ба инновацийн Факультет** (эдийн засаг, менеджмент, маркетинг, технологийн инновацийн удирдлага).

Шинжлэх ухааны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл: IT, фотоника, робототехника, квантын харилцаа, трансляци анагаах ухаан, хот байгуулалт, Art & Science, Science Communication.

Сургуулийн албан ёсны сайт: www.itmo.ru

ХАРИЛЦАХ МЭДЭЭЛЭЛ
ТУС СУРГУУЛЬД ЭЛСЭХ АСУУДЛААР:
Гадаад оюутны сургалтын төв
Захирал: Серова Марина, тел.: +7 (812) 314-77-75
E-mail:int.students@corp.ifmo.ru

ХАРИЛЦАХ МЭДЭЭЛЭЛ
ХАМТРАН АЖИЛЛАХ АСУУДЛААР:
Олон улсын хамтын ажиллагааны газар
Дарга: Ким Ирина, тел.:+7(812) 315-28-41
E-mail:kim@mail.ifmo.ru

САНКТ-ПЕТЕРБУРГИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Санкт-Петербургийн улсын их сургууль нь Орос улсын маш эртний дээд сургууль бөгөөд дэлхийн хэмжээний шинжлэх ухаан, соёл, боловсролын төв юм. Тус их сургууль нь Европ тивийн хамгийн алдартай соёл, аялал жуулчлалын хот хэмээн нэг биш удаа хүлээн зөвшөөрөгдсөн Санкт-Петербург хотноо байрладаг.

Санкт-Петербургийн улсын их сургууль ньерөнхий боловсролоос ординатур хүртэлх түвшний 418 сургалтын хөтөлбөрөөр элсэлт авч байна. Хөтөлбөрүүдийн дийлэнхи нь модуль сургалтаар зохион байгуулагддаг нь үндсэн ба нэмэлт сургалт сонгуулснаар оюутан тус бүрийн онцлогт нийцүүлэн мэдлэг эзэмшүүлэх аргыг тохируулах боломжтой болсон юм. Үүнээс гадна сургалтын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны хэд хэдэн салбарын мэдлэгийгоюутанд нэгэн зэрэг эзэмшүүлэхүйц хичээл хоорондын харилцааг тусгасан агуулгатай нь бусад сургуулиудаас давуу талтай.

Санкт-Петербургийн улсын их сургууль нь өөрийн нөөцийн баазын тусламжтайгаар ОХУ-ын тэргүүний Шинжээчийн төв болж чадсан. Шинжлэх ухааны парк нь суурилуусан тоног төхөөрөмж, технологийн боломжоороо улсдаа дээгүүр орох ба зарим чиглэлээрээ дэлхийд ч онцгой байр эзэлдэг.

Тус их сургууль нь олон улсын 40 байгууллага, Холбоодын бүрэлдэхүүнд багтаж үйл ажиллагаа явуулдаг. Мөн хөрвөх боломжтойсургалтын хөтөлбөрүүдийн хүрээнд түншлэлийн харилцаатай их, дээд сургуулиудтайгаа идэвхитэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж ирсэн. Гадаад оюутнуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хэд хэдэн хөтөлбөртэй:үүнд бадди, интродолоо хоног, эсвэл тусгай клуб-д элсэх боломж зэрэг орно.

Санкт-Петербургийн улсын их сургуульнь Times Higher Education, QS World University Rankings, Academic Ranking of World Universities зэрэг байгууллагын дэлхийн шилдэг их, дээд сургууль шалгаруулахсудалгаагаартэргүүлэх үзүүлэлттэй их сургуулийн тоонд зүй ёсоор багтаж байна.

Financial Times European Business School Ranking 2018 –аар 57-д, харинFinancial Times Global Masters in Management 2018 – аар магистрын түвшний "Менеджмент" хичээл нь 23-т, QS Graduate Employability 2018 –аар "Ажил олгогч байгууллага ба оюутны хамтын ажиллагаа"үзүүлэлтээр дэлхийн шилдэг 400 их, дээд сургуулийн 20-т эрэмблэгдсэн ба ОХУ – ын тэргүүний их сургууль болж чадсан.



ХОЛБОО БАРИХ:
Гадаад оюутан элсүүлэх комисс Хаяг: Россия, 199034, Санкт-Петербург, Университетская набережная д. 13, литер Б
Ажиллах цаг : Даваа – Баасан гариг, 10.00- 18.00
Утас: +7 (812) 363-66-33, E-mail:admission@spbu.ru
Сайт: spbu.ru, abiturient.spbu.ru

Г.В.ПЛЕХАНОВЫН НЭРЭМЖИТ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

Г. В. ПЛЕХАНОВЫ НЭРЭМЖИТ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ СУРАЛЦАХЫГ УРЬЖ БАЙНА!

Г.В. Плехановын нэрэмжит ОЭЗИС-ийн Улаанбаатар дахь салбар сургууль 1999 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн ба 18 жилийн туршид эдийн засаг, санхүүгийн салбарт өндөр мэргэжилтэй мэргэжилтнүүдийг төгсгөн гаргаж байна.

Тус сургуульд чанартай дээд боловсрол олж авах бүх нөхцөл бүрдсэн: оросын холбооны стандарт боловсролын хөтөлбөртэй,

хичээлийн танхимууд орчин үеийн техник тоноглолтой, оюутан бүрт ганцаарчлан хандах боломжтой, найрсаг хамт олон, оюутны гайхалтай амьдралтай.

Профессор-багш нарын бүрэлдэхүүн – оросын болон гадаадын эрдэм шинжилгээний нэртэй сэтгүүлүүдэд өгүүлэл материал нийтлүүлж, сурах бичиг, гарын авлаг зохиосон өндөр мэргэжлийн мэргэжилтэн багш нар. Олон багш мэргэжлээрээ консалтингийн болон судалгаан шинжилгээний төслүүдэд оролцдог практик туршлагатай бөгөөд оюутнуудынхаа эрдэм шинжилгээний төсөл, өгүүлэл, нийтлэлүүдийн эрдэм шинжилгээний удирдагч нь болдог.

Бакалавр бэлтгэх чиглэл **«Эдийн засаг», мэргэжил «Санхүү, зээл», 4 жил**

Элсэн суралцах нөхцөл: Анхны дээд боловсрол олж авах Монгол Улсын иргэд элслэтийн шалгалт өгч орно:

- Математик (мэргэжлийн);
- Орос хэл;
- Англи хэл

БИДНИЙ ДАВУУ ТАЛ

- Улаанбаатар хотод суралцаад Москвад байх төв сургуулийнхаа дипломыг илүү бага өртгөөр авна;
- Ихэнх хичээлийг Москвагаас ирсэн багш нар заадаг;
- Солилцоогоор төв сургуульдаа суралцах боломжтой;
- Нэгдүгээр курсийн оюутнууд квартир маягийн дотуур байранд үнэ төлбөргүй амьдрана;
- Оюутны сонирхол дүүрэн амьдрал: КВН, спортын уралдаан тэмцээн, соёл, эрдэм шинжилгээний арга хэмжээнүүд;
- Шилдэг оюутнуудад олгодог стипенд

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Адрес: 210351, Монгол Улс, Улаанбаатар, Энх тайвны өргөн чөлөө 131
E-mail: ulan-bator.pk@rea.ru / Веб-сайт: www.rea.ru
Тел: +976-9595-1429 (Viber, WhatsApp); Мы в социальных сетях: Plekhanovka_UB, Фейсбук: UBpleshka
8-10-976-11-45-05-96; 8-10-976-11-45-06-79

ТОМСКИЙН ПОЛИТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛЬ

1896 онд байгуулагдсан ба Үндэсний судалгаа-шинжилгээний их сургуулийн статустай. ТУИС нь Орос орондоо инженерийн боловсрол олгох лидер их сургуулийн нэг(Оросын их сургуулиудын Топ-10 сургуулийн тоонд ордог.). Тус их сургуульд 12000 гаруй оюутан суралцагаас 4000 орчим нь дэлхийн 49 орноос ирсэн гадаад оюутнууд юм. Сургууль нь дэлхийн тэргүүлэх судалгаа- шинжилгээ-боловсролын төвүүдийн дунд оросын шилдэг их сургуулиудын өрсөлдөх чадвараа дээшлүүлэх "5-100" төсөлд түрүүлсэгсдийн нэг юм.

ТПИС нь олон улсын CESAER, CLASTER консорциум, БРИКС сүлжээний их сургуулийн гишүүн басургуулийн боловсролын 40 хөтөлбөр нь олон улсын ABE , EUR-ACE байгууллагуудын гэрчилгээг авсан.

ТПИС нь QS WorldUniversityRankings рейтингэд 373-р байрыг эзэлдэг. ТПИС-д элсэгчид бакалавр, магистр, аспирантын 90 хөтөлбөрөөс техникийн чиглэлээр орос хэл дээр сонгон суралцах боломжтой. ТПИС бакалавр, магистр, аспирантурт орос, англи хэл дээр элсэн суралцах Бэлтгэл ангийн хөтөлбөрийг санал болгож байна. ТПИС-ийн Бэлтгэл ангийн боловсролын уян хатан хөтөлбөр нь дээд сургуульд элсэн суралцахад бэлтгэх боломжийг олгодог ба орос хэл болон мэргэжлийн хичээлүүдийг судлахаас гадна монголын их дээд сургууль төгсөгчид магистр, аспирантурт суралцах боломжтой. ТПИС нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 105–р дунд сургууль дээр дээд сургуульд элсэн суралцахад бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Сургууль нь CDIO үзэл баримтлалыг барин, оюутнуудыг сургалтын хувийн хөтөлбөрөөр хичээллүүлэх боломжийг бий болгосон (орос, англи хэл дээр сургах). Оюутнууд хэлний курсийг сонгон, олон улсын TORFL, PET, FCE, CAE, CPE, IELTS шалгалтуудыг өгөх боломжтой.

Сургууль нь Double-Degree болон дэлхийн 25 орны 90 их сургуультай академик солилцооны хөтөлбөр болон бусад хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. ТПИС нь

ТПИСнь "Время учиться в России!" төсөлд оролцдог ба "Чиний анхны амжилт" олимпиадыг зохион байгуулдаг. Эдгээр нь гадаадын оюутнуудад ТПИС-д элсэх, үнэгүй болон хөнгөлөлттэй суралцах боломжийг олгодог юм. ТПИС гадаад оюутнуудад бүхий л тусламжийг олгодог: тохилог дутуур байр, нисэх онгоцны буудал, вокзал дээр угтах, виз авч өгөх, эрүүл мэндийн даатгалд хамруулах, элсэх барит бичгийг бүрдүүлэх г.м.

Томскийн политехникийн Үндэсний судалгаа-шинжилгээний их сургуульд суралцах нь ажил мэргэжлээрээ амжилттай ахих, сайхан ирээдүйд хүрэх анхны алхам юм.



ХОЛБОО БАРИХ:
Гадаад оюутнуудтай ажиллах хэлтсийн ерөнхий эксперт
Баловнева Алла Николаевна
Tel./Fax: +7 (3822) 606-476
Email: balovneva@tpu.ru, omrs@tpu.ru
www.iie.tpu.ru, www.tpu.ru

ТУСУР | TUSUR UNIVERSITY

Tomsk State University of Control Systems and Radioelectronics

- Тус сургууль төгсөгчдийн 85% нь төгсөөд анхны жилдээ ажилд ордог;
- Тус сургууль төгсөгчд Томскийн бусад их сургууль төгсөгчдөөс илүү өндөр цалин авдаг(ОХУ-ын боловсролын яамны ажилд оруулах мониторингийн судалгааны дагуу);
- Үйлдвэрлэл эрхлэх, судалгаа-шинжилгээний тэргүүлэх их сургууль;
- Оросын оюутны анхны бизнес-инкубатор;
- Оросод анхны технопарк;
- Дэлхийн тэргүүлэх 19 үйлдвэрлэл эрхлэх их сургуулийн нэг (Массачусетийн технологийн институтийн судалгаа ёсоор (MIT) 2013 г.),
- QS Starsдөрвөн одон: Их Британы консалтингийн QS QuacquarelliSymondskомпани ТУРЭСИС-ийн үйл ажиллагааг хэд хэдэн үзүүлэлтээр судалсан бөгөөд сургууль нь «боловсрол», «төгсөгчдийг ажилд оруулах», «инноваци» «дэд бүтэц» гэсэн үзүүлэлтээр хамгийн дээд үзүүлэлийг үзүүлсэн(таван од).
- Сургуулийн нийт оюутны 18% нь гадаад оюутнууд;
- Гадаад оюутны тоогоор оросын их сургуулиудын дунд 7-р байр эзэлдэг (QS UniversityRankings байгууллагын олон улсын рейтинг үзүүлэлтээр :EECA – 2019);
- 36 орноос оюутнууд суралцдаг;
- АНУ, Франц, Япон, Казахстаны их сургуулиудтай хэрэгжүүлдэгDoubleDegree хөтөлбөрүүдтэй;
- Нийт европын загварын дипломын хавсралт;
- Сургалтын боломжийн үнэ (99000 рубль);
- Гадаад оюутнуудад зориулсан хямд, тохилог дотуур байр(2018 онд сарын 1200 рубль байсан.);
- Спортын 29 секц: сагс, гар бөмбөг, хөл бөмбөг болон бусад.;
- Орчин үеийн онлайн технологийг ашиглан боловсролын процессийг хэрэгжүүлдэг зайн сургалтын хамгийн том төв.

Бэлтгэл факультет нь бакалавр, магистрын хөтөлбөрөөр сурахад орос хэлийг хангалтгүй мэддэг гадаад оюутнуудад зориулсан хөтөлбөрийг санал болгодог. Хөтөлбөр 1 жилийнх.

Техникийн мэргэжлээр сургадаг.

Томск нь Сибирийн шинжлэх ухаан-боловсролын төв. Томск хот нь татах чадвар, энгийн байдал, аюулгүй байдал, оюутны дотуур байрны тохижолтын түвшнээрээ Оросд 2-р байр, санхүүгийн боломжийн байдлаар 1-р байрыг эзэлдэг(олон улсын рейтингийн QS агентлагийн үзүүлэлтээр, Их британа). Өнөөдөр Томскт9 их сургууль, 11 эрдэм шинжилгээний хүрээлэн, техник нэвтрүүлэх маягийн эдийн засгийн онцгой бүс, 6 бизнес-инкубатор, олон тооны лаборатори, зохион бүтээх товчоо ажилладаг.

ТУРЭСИС-ийн факультетууд:

- Радиотехникийн факультет
- Радиозохион бүтээх факультет
- Тооцоолох системийн факультет
- Удирдлагын системийн факультет
- Электрон системийн факультет
- Инновацийн технологийн факультет
- Эдийн засгийн факультет
- Хүмүүнлэгийн факультет
- Хуулийн факультет
- Аюулгүй байдлын факультет
- Зайн сургалтын факультет.



ХОЛБОО БАРИХ:
г.Томск, пр.Ленина, 40, 634050, тел.+7 (3822) 510-804
www.tusur.ru, interedu.tusur.ru
inter@main.tusur.ru

САНКТ-ПЕТЕРБУРГИЙН УУЛЫН ИХ СУРГУУЛЬ

Тус их сургууль нь 1773 онд хатан хаан Екатерина II зарлигаар Оросын анхны техникийн их сургууль болон байгуулагдсан түүхтэй.

Уулын их сургууль нь Оросын Холбооны улсын соёлын өвийн үнэт зүйл хэмээн тооцогддог бөгөөд Орос улсын Үндэсний судалгааны их сургуулиудын нэг.

Уулын их сургууль Их Британийн дэлхийн шилдэг их, дээд сургуулийг шалгаруулах QS World University Rankings- н судалгаагаар (2019 оны 2-р сарын 27-ны үр дүнгээр) "Ашигт малтмал олборлолт, уул уурхайн аж үйлдвэрийн инженер " чиглэлийн сургалтаараа 19-рт багтаж сүүлийн 3 жил дараалан шилдэг инженер техникийн их сургуулийн ТОП-20-д эрэмбэлэгдсэн.

Уулын их сургуулиас дэлхийд алдар цуутай маш олон эрдэмтэд төрсөн. Тэдгээрийн дотор академич А.П. Карпинский, Е.С Федоров, В.А. Обручев, Н.С. Курнаков, Н.Г. Келль, Д.В. Наливкин, И.М. Губкин, А.П. Герман, А.А. Скочинский нарыг нэрлэж болно.

Түүнчлэн ОХУ-ын ерөнхийлөгч В.В Путин, Монгол улсын анхны ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, Таджикистан улсын анхны ерөнхийлөгч Махкамов К.М. зэрэг төрийн тэргүүнүүд тус их сургуулийн төгсөгчид юм.

2018 оны 3-р сарын 7-ны өдөр Парис хотноо ЮНЕСКО-гийн ивээл дор Санкт-Петербургийн Уулын их сургуулийг түшиглэн Уул уурхайн техникийн Олон улсын боловсролын төв /Центр компетенций/ байгуулах гэрээнд гарын үсэг зурагдсан байна.

Их сургуулийн Уул уурхайн музей нь сан хөмрөгтөө 80 гаруй орны 240 орчим мянган шилдэг үзүүлбэрийн цуглуулгатай. Тиймээс дэлхийн байгаль шинжлэлийн хамгийн алдартай музейнүүдийн эхний гуравт багтдаг. Маш баялаг Шинжлэх ухаан, техникийн номын сан нь XV – XIX зууны үеийн үнэт ховор 1,2 сая гаруй бүтээл, ном хэвлэлтэй, орчин үеийн компьютероор тоноглогдсон, электрон каталогоор үйлчилдэг.

Уулын их сургууль нь Санкт-Петербург хотын түүхэн төвд байрлах ба түүний бусад хичээлийн байр, орчин үеийн тохилог оюутны байрууд нь зэргэлдээ оршдог.

Одоо тус их сургуульд дэлхийн 70 гаруй орны 8000 гаруй оюутан «Архитектур», «Барилга», «Ховор барилга байгууламжийн барилга», «Хэрэглээний геодези», «Хэрэглээний геологи», «Геологи хайгуулын технологи», «Уул уурхай», «Экологи», «Мэдээлэл зүй ба тооцолон бодох техник», «Дулааны эрчим хүч ба дулааны техник», «Цахилгаан эрчим хүч ба цахилгаан техник», «Машин байгууламж», «Технологийн машин ба тоног төхөөрөмж», «Технологийн үйл ажиллагаа ба үйлдвэрлэлийн автоматжуулалт», «Химийн технологи», «Техник орчны аюулгүй байдал», «Газрын тос, байгалийн хий», «Газар зохион байгуулалт ба кадастр», «Металлург», «Тээврийн технологи», «Эдийн засаг», «Менежмент» зэрэг мэргэжлийн чиглэлээр суралцаж байна.

Уул уурхайн их сургууль нь хоёр спорт цогцолбор, усан сан, эрүүл мэндийн сургалтын баазтай. Оюутны байрууд нь өөрийн гуанз, биеийн тамирын заал, угаалгын өрөөтэй.

Хувиараа суралцдаг оюутнуудад дүрэмт хувцас үнэгүй олгогддог.

ХОЛБОО БАРИХ:
Гадаад оюутны асуудал эрхэлсэн албаны утас: +7 (812) 328-82-55.
УУИС –ийн сайт www.spmi.ru
Е-майл хаяг: foreign@spmi.ru

ПРИВОЛЖИЙН АНАГААХЫН СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ

Приволжийн анагаахын судалгааны их сургуульбол эртний их сургуулиудын нэг юм. Их сургууль шинжлэх ухаан-судалгаа, сургалт-хүмүүжлийн ажлаа дэлхийн болон өөрийн орны сонгодог уламжлалд түшиглэн боловсрол анагаахын салбарын орчин үеийн зарчим, шинэ хандлагыг удирдлага болгон амжилттай хэрэгжүүлж байна.

«Приволжийн анагаахын судалгааны их сургууль» боловсролын байгууллага төдийгүй бүрэлдэхүүндээ их сургуулийн эмнэлэг, хүүхдийн эмчилгээ, гэмтэл согог судлал, шүд, эрүү амсудлал, ерөнхий анагаахын дээд сургууль, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, өндөр технологийн ажиллагаа, шинжлэх ухааны судалгаа явуулах боломжтой урьдчилан сэргийлэх анагаах ухаан, туршилтын хавдар судлал, био анагаахын технологийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй.

Их сургуульд 4 мянга гаруй /орос тоо баримтаа хараарай/!!!!! оюутан суралцаж байгаагийн 1000 гаруй нь дэлхийн 58 орноос ирж суралцаж байгаа гадаад оюутан байна.

«Приволжийн анагаахын судалгааны их сургууль» дараах мэргэжлээр элсэн суралцахыг санал болгож байна. **Үүнд**:

– Эмчилгээ, суралцах хугацаа – 6 жил;

– Шүд, эрүү ам судлал, суралцах хугацаа – 5 жил;

– Эм зүй, суралцах хугацаа – 5 жил.

Сургалт англи, орос хэлээр явагддаг. Гадаадын элсэгчдийн мэргэжлээ бүрэн дүүрэн эзэмшин нөхцөлийг бүрдүүлэх орос хэлний бэлтгэлийг Н.А.Добролюбовын нэрэмжит Нижегородын хэл шинжлэлийн их сургуульд түшиглэх явуулахаар төлөвлөж байна.

Гадаадын орнуудаас элсэгчид /ОХУ-ын иргэн биш/ засгийн газар хоорондын гэрээний үндсэн дээр элсэнэ.

Элсэгчдийн боловсролын түвшин ОХУ-ын бүрэн дунд ерөнхий боловсролын түвшинтэй нийцэж байх шаардлагатай. Боловсролын бичиг баримтыг консулын газар баталгаажуулсан байна.

Жилийн сургалтын төлбөр сонгосон мэргэжил, инфляцийн



түвшнээс хамаарч 240000-315000 /орос тоо баримтаа хараарай/ рубль байна.

Элсэгчдийг хотын зам тээвэр, соёлын дэд бүтэц сайн хөгжсөн дүүргүүдэд тохилог сургуулийн тохилог оюутны байранд амьдрах боломж олгоно.

ХОЛБОО БАРИХ:
Ректор: Николай Николаевич Карякин
Байрлах хаяг: Минина и Пожарского пл., 10/1, г. Нижний Новгород, 603950, БОКС-470
Утас: 8 (831) 439-09-43; факс: 8 (831) 439-01-84
Сайт: http://pimunn.ru/, Е-майл: rector@pimunn.ru, interstudy@pimunn.ru

ГОРНО-АЛТАЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Горно-Алтайн улсын их сургууль нь 1949 онд байгуулагдсан ба Алтайн Бүгд Найрамдах Улсын хамгийн том боловсрол-шинжлэх ухааны цогцолбор юм. Горно-Алтайн байгалийн баялаг, түүх-соёлын өв нь янз бүрийн бүс нутгуудад өндөр мэргэшсэн мэргэжилтнүүд бэлтгэх шимтэй суурь болсон юм.

Өнөөдөр Горно-Алтайн улсын их сургууль нь орчин үеийн бүхий л шаардлагад нийцсэн эрчимтэй хөгжиж байгаа их сургууль юм. Олон хөтөлбөрөөрөө тус их сургууль нь олон талын мэргэжил олгодог их сургууль гэж зүй ёсоор тооцогддог ба 40 гаруй чиглэлээр бакалавр, мэргэжилтэн, магистр, аспирант, мэргэжлийн дунд боловсролыг олгодог. Нэмэлт боловсролын хөтөлбөрийг хөгжүүлэхэд их анхаарал тавьж байна. Сургуулийн дэргэдэх хуулийн клиник, мал эмнэлэгийн клиник, агробиологийн станц, музейн цогцолбор, олон тооны лабораториуд дээр оюутнууд практик дадлыг олж авдаг.

Тус их сургууль Бельги, Герман, Энэтхэг, Казахстан, Киргиз, Хятад, Өмнөд Солонгос, Монгол, АНУ-ын олон их сургуультай нягт хамтран ажиллаж байна. ГАУИС дээр жил бүр олон орны нэртэй болон залуу эрдэмтдийг нэгтгэсэн олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, семинар, зуны сургуулиуд зохиогддог.

ГАУИС–ийн сургалт нь
- Чанартай боловсрол
- Орчин үеийн лабораторийн хичээл
- Хээрийн практик, экспедиц
- Тухлаг дотуур байр
- Оюутан бүрт зориулсан спорт
- Дэлхийн янз бүрийн өнцөг булангаас ирсэн найз нөхөд юм.

Сургуулийн бүтэц:
- Байгаль-газар зүйн факультет
- Түүх-хэл шинжлэлийн факультет
- Эдийн засаг-хуулийн факультет
- Сэтгэл судлал-сурган хүмүүжүүлэх факультет
- Алтай, турк судлалын факультет
- Физик-математик, инженер - технологийн институт
- Хөдөө аж ахуйн коллеж

ХОЛБОО БАРИХ:
649000, г. Горно-Алтайск, ул. Ленкина, 1
Элсэлтийн комисс: (38822) 6-73-66
e-mail: prikom@gasu.ruwww.abit-gasu.ru

ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

Тус их сургууль нь 1992 онд байгуулагдсан. Хөгжлийнхөө 25 жилийн хугацаанд олон үзүүлэлтээр улс орны шилдэг их дээд сургуулиудын дунд тэргүүлэх байр сууринд хүрч, тасралтгүй хөгжиж байна.

QS World University Rankings-ийн 2018-2019оны жагсаалтаар«Эдийн засгийн дээд сургууль»дэлхийн шилдэг 2500 сургуулиас 343-рт эрэмбэлэгдэж, эдийн засаг, эконометр, социологи, санхүү, улс төр, олон улсын харилцаа, бизнес, менежментийн чиглэлээр оросын их сургуулиудын дунд тэргүүлэх байр суурь эзлэх болсон. Түүнчлэн нийгмийн ухаан, математик, эрх зүй, философи, түүх, хэл шинжлэл чиглэлээр Оросын 5 тэргүүлэх их сургуулийн нэгд тооцогддог.

Өнөөдөр сургуулийн Москва, Санкт-Петербург, Нижний Новгород, Пермийн хотхонуудад 40 мянга гаруй оюутан, аспирант суралцдаг бөгөөд бакалаврын 80, магистрын 165 хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг.

«Эдийн засгийн дээд сургууль» Лондонгийн их сургууль, Лондонгийн эдийн засаг, улс төрийн шинжлэх ухааны дээд сургууль, түүнчлэн Сеул хотод байрлах Кен-хи их сургуультай хамтарсан бакалаварын хөтөлбөрөөр хос диплом олгох ховор боломж олгож байна. Магистрын хөтөлбөрт хос диплом олгох 40 түншлэгч байна. Энэхүү сургалтын хөтөлбөрөөр олж авсан боловсролыг Эдийн засгийн дээд сургуулийн болон түншлэгч их дээд сургуулийн дипломоор баталгаажуулна. Ийм боловсрол

мэргэжилтний хөрвөх чадвар сайн, хөдөлмөрийн зах зээл дээрх хэрэгцээ их байхыг гэрчилнэ.

«Эдийн засгийн дээд сургууль»өнөөдөр дэлхийн хүмүүст нээлттэй их сургууль болсон. Дэлхийн 39 орны 3300 оюутан суралцаж байна. Гадаадын суралцагчдад зориулсан орос хэлний бэлтгэл, мэргэжлийн хичээл, бакалавр магистрын англи хэлээр явуулах олон хөтөлбөртэй.

Одоогийн байдлаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдээрээ 72 мянган мэргэжилтэн бэлтгэн гаргаад байна.

«Эдийн засгийн дээд сургууль»-ийн диплом оросын болон дэлхийн шилдэг компаниудад ажиллаж хурдан ахиж, амжилтад хүрэх нөхцөл бүрдүүлэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэх баталгаа болно.

Жил бүр «Эдийн засгийн дээд сургууль»-ийг түшиглэн 500 гаруй суурь, хавсарга судалгааны төсөл хэрэгжиж, 1000 гаруй социологийн судалгаа хийгдэж байна. Сургуулийн эрдэмтэн судлаачид эшлэл авагддаг олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдэд бүтээлээ хэвлүүлж байна. Түүнчлэн 18 мянга гаруй тогтмол болон цуврал хэвлэлийг авч хэрэглэх боломж олгодог, оросын бусад их дээд сургуулиудаас ялгарах ховор номын сантай юм.

ХОЛБОО БАРИХ:
HSE International Admissions
Office 105, 13/4 Myasnitskaya str., Moscow 101000 Russian Federation
E-mail: inter@hse.ru, Tel: + 7 495 531 00 59, Website: https://www.hse.ru/en/

ТОМСКИЙН УЛСЫН АРХИТЕКТУР-БАРИЛГЫН ИХ СУРГУУЛЬ

Томскийн улсын архитектур-барилгын их сургууль нь 1952 онд байгуулагдсан.

Их сургууль нь Оросын шинжлэх ухаан, боловсролын тэргүүлэх төвийн нэг болох Томск хотын их сургуулийн хуучин хотхонд оршдог. Тус хот нь оюутны эзлэх хувиарааОрос Улсдаа Москва, Санкт-Петербургийн дараа 3-рт ордог. Томск хотын 5 оршин суугчийн нэг нь оюутан. Тиймээс Томск хотыг «оросын Оксфорд» хэмээн нэрлэдэг.

ТУАБИС өнөөдөр архитектур, барилгын салбарт тэргүүлэх сургуулийн нэг бөгөөд

Оросын ТОП-100 их сургуулийн тоонд багтаж, мэргэлийн их сургуулийн дунд 2-р байрыг эзэлдэг. ТУАБИС-гийн бүтцэд 6 институт(түүний дотор олон улсын харилцаа, болон боловсролыг интернационалжуулах институт), 6 факультет(Архитектурын, Барилгын, Зам-барилгын, Механик-технологийн, Ерөнхий боловсролын болон Дунд-тусгай боловсролын факультет), орчин үеийн оюутны архитектур-барилгынбизнес-инкубатор, геодезийн полигон, шинжлэх ухааны номын сан, лабораторууд, олон улсын түвшний төвүүд ордог.

ТУАБИС-д 5950 оюутан суралцдагаас 1435 нь Монгол, Хятад, Турк, Марокко, Алжир, Йемен, Камерун, Конго, Кот д'Ивуар, Казахстан, Узбекистан, Кыргызстан болон бусад орноос ирсэн гадаад оюутнууд юм. Гадаад оюутнуудад зориулсан Бэлтгэл анги байдаг ба түүнд ирээдүйн оюутнууд ОХУ-ын боловсролын яамны шаардлагад нийцүүлсэн орос хэл, ерөнхий боловсролын хичээлийг сурдаг. Оюутнууд мөн энд мэдээллийн, визийн, академик болон нийгэм-соёлын туслалцаа, дэмжлэгийг авдаг.

